

2023 оны 06 дугаар сарын 29-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Долоодугаар сард 175 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 35 ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна. Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 205 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Нийт ирүүлсэн өргөдөл 17 (гэр хүссэн-1, өөр ажилд томилогдох-1, ажлын байр хүссэн-15) байна.

Ерөнхий боловсролын сургууль :

- Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жилийн ажлын хүрээнд АУБ нар, Хүүхэд хамгааллын багийн тогтмолжсон үйл ажиллагааны нэг болох "Хариуцлагатай багш гэрээр айлчлах" үйлчилгээг нийт 364 сурагчдад, УРЬДЧИЛАН сэргийлэх 27 төрлийн сургалт мэдээллийг 748 сурагч, эцэг эхэд хүргэснийг 2022-2023 оны хичээлийн жилд АУБ нараас тоог авч нэгтгэлээ. Энэ хичээлийн жилд ХАМГИЙН ИХ айлчлал, ТЭМДЭГЛЭЛ бичсэн бага ангийн багш Д.Мөнхжаргал, Англи хэлний багш Натарцэцэг, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТ МЭДЭЭЛЛИЙГ: Бага ангийн багш Ж.Мөнх-Од, Түүх нийгмийн ухааны багш Ц.Алтантүлхүүр нарыг сумын ИТХ-аас шагнаж урамшууллаа.
- ОНХС-гийн 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЕБС-ийн номын сангийн тохижилт, номын баяжилт хийгдлээ.
- Улсын болон анги дэвших шалгалтуудыг хууль дүрмийн дагуу зохион байгуулж улсын шалгалтыг 5,9 дүгээр ангийн 92 суралцагч нийт 7 төрлийн хичээлээр, анги дэвших шалгалтыг 3,4, 6-8 дугаар ангийн нийт 266 суралцагч нийт 3 төрлийн хичээлээр амжилттай өгсөн.
- “Байгалийн ухааны хичээлээр сурагчдын илэрхийлэх чадварыг дэмжих нь” төслийн сургалтад захирал, менежер, бага ангийн багш нар хамрагдаж бага боловсролын байгалийн ухааны сургалтын хөтөлбөрийн талаарх ойлголтоо нэгтгэсэн.
- Сургалтын орчинд хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор хичээлийн байрны өгсөж уруудах шатны хажуу ханыг акустик хавтангаар доторлов. Орон нутгийн төсвөөс 658000 төг зарцуулсан.
- Багш, ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор фитнесийн өрөө гаргаж орон нутгийн төсвөөс 1,000,600 төгрөгөөр тохижууллаа.
- Дотуур байрын номын сан, эцэг эх хүүхдүүдийн уулзалтын өрөөг орон нутгийн төсвөөс 1,506,000 төгрөгөөр тохижуулав.

- БШУЯ-наас хэрэгжүүлж буй “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн санхүүжилтээр Боловсролын ерөнхий газар аймгийн Боловсролын газраас хамтран зохион байгуулсан “Тэгш хамруулан сургах онол арга зүйн сургалт”-д захирал, сургалтын менежер -2, нийгмийн ажилтан, бага ангийн 10 багш \нийт 14\ хамрагдсан.
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агенлаг ГБХЗХГ-аас Дорноговь аймагт Зүүн бүсийн аймгуудийг хамруулан зохион байгуулагдсан “Хүүхдийн хөгжлийн хөтөлбөр” сэдэвт сургалтад нийгмийн ажилтан Т.Вера, 3 суралцагчийн хамт оролцлоо.
- Баруун-Урт сумын ЗДТГ, аймгийн НТБТ-өөс зохион явуулсан "Эх бичиг - Цахим орчинд" уралдаанд 4 шалгуурын дагуу байгууллагаараа амжилттай оролцсон.

Хүүхдийн цэцэрлэг:

- Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу 9,714,500төгрөгийн 157ш тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэгдлээ.
- “Онлайн кабенит” төсөл хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн 11,900,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар "ухаалаг дэлгэц"-ийг хүлээлгэн өгсөн.

Эрүүл мэндийн төв:

- Нийт үзлэг - 1668
- Амбулаторын үзлэг- 746
- Урьдчилан сэргийлэх үзлэг – 559
- Идэвхитэй хяналт – 28
- Гэрийн дуудлага –341
- Артерийн даралтын үзлэг – 115
- Чихрийн шижингийн үзлэг –141
- Хөхний үзлэг – 103
- 0-2 насны 21 хүүхдийг товлот дархлаажуулалтанд бүрэн хамруулсан байна. Улаан бурхан улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтанд 10 сараас 8 насны 505/353/хүүхдийг
- Хамруулж хамралтын хувь 69,9% байна.

Лабораторийн шинжилгээнд:6 байдлаар

Шээсний ерөнхий шинжилгээ -123

Цусны ерөнхий шинжилгээ-151

Үе мөч -91

Бруцеллёз-15

Дох, Тэмбүү-217

Сахар-19

Элэгний В,С вирус -28

Цэрний сорьц авах-20

Бүлэг тодорхойлох-6

Хеликобактер-16

Эрүүл мэндийн ажилчдын дархлал тогтоцын шинжилгээний сорьц 16 хүнээс авч эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.

Томуугийн вирус тогтоох шинжилгээ 5 хүүхдээс авч АНЭ-рүү илгээсэн.

Элэг бүтэн хөтөлбөрийн хүрээнд 6 хүн шинжилгээнд хамруулсан.

Үүнээс : В,С вирустэй хүн илрээгүй.

Бэлгийн замын шинжилгээ 217 хүнд хийсэн.

Үүнд: Өөрчлөлттэй 26 хүний 6 хүний хариу илгээгдээд ирсэн

20 шинжилгээний ийлдсийг нь ялган авч АНЭ –рүү сорьцыг илгээхээр бэлтгэн хөлдөөсөн.

Сүрьеэгийн сорьц тээвэрлэлтээр 10 хүний 20 сорьц илгээсэн.

Үүнээс: Өөрчлөлттэй шинжилгээ байхгүй.

Соёлын төв:

ЕБС, Соёлын төвийн дэргэдэх найрал дуу, хөгжим, бүжгийн дугуйлангийн хүүхдүүд **“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”** буюу 06 сарын 01-нд **“МӨРӨӨДЛИЙН ЖИГҮҮРТЭЙ ХҮҮХЭД НАС”** тайлан тоглолтоо зохион байгуулсан. Нийт 560 хүн үзэж сонирхлоо.

НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА: Нийтээр тэмдэглэх “номын баярын өдрийг” тохиолдуулан 06 сарын 07-нд **“ЭХ НУТАГАА ХАЙРЛАЯ”** уриатай номын үзэсгэлэн зохион байгууллаа. Номын үзэсгэлэнд нийт 60 гаруй ном дэлгэгдэж, 90 гаруй хүн үзэж сонирхсон. Мөн ном унших сонирхолтой хүмүүс карт нээлгэн гэрээр ном авч уншиж, оюундаа үнэтэй хувь нэмэр оруулж байна.

ДӨРӨВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1 Сумынхаа түүхэн дурсгалт газруудыг танин мэдэх зорилгоор ЕБС-ийн 9дүгээр ангийн хүүхдүүдийг нэгэн өдөр цэвэр агаарт гарган, сумынхаа байгалийн сайханыг үзүүлж, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах, түүхэн дурсгалт газруудыг суртачилан таниуллаа. Үүний хүрээнд: Монголын уламжлалт өв соёлын талаарх АХА тэмцээн зохион байгуулсан. Нийт 38 хүүхэд оролцлоо.

4.2 06 сарын 03-ны өдөр **маршрут** гарган булш бунхан, хадны зосон зураг гэх мэт газруудаар явж, бүртгэн баримтжуулах ажил амжилттай явагдлаа.

4.3 “Соёлын сэргэлт 2023” аяны хүрээнд: Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нар “Гар урлалын үзэсгэлэн”-г Соёлын төвийн танхимд зохион байгууллаа. Үзэсгэлэнд нийт 5 төрлийн 80 гаруй бүтээл дэлгэгдэж олны хүртээл болсон юм.